



Жирэмсэн вед эм хэрэглэх нь хамгийн түвэгтэй, хариуцлагатай асуудлын нэг юм. Учир нь жирэмсэн вед эхийн хэрэглэсэн эм эхэсээр дамжин урагт хврч төрөл бүрийн сөрөг нөлөө үзүүлж болно.

Эм урагт хэрхэн нолоолох нь жирэмсний хугацаанаас хамаардаг.

- Эхний 17 хоногт үр ховрол хоноогдох буюу хортой нолоо үзүүлдэг.
- Үр ховролийн эрхтэний тогтолцооны хогжлийн вед (18-55 хоногт) аль нэгэн эрхтэн системийн гаж хогжил үүсч болно.
- Ургийн осолт хогжлийн үе буюу 56 хоногоос хойших вед эмийн нолоогоор ургийн хогжил саатах, эрхтэн системийн үйл ажиллагааны эмгэгүүд үүсч болно.
- Торохийн омдох 1 сар орчмын үе буюу жирэмсний сүүлийн сард хэрэглэсэн эм эхийн торох үйл ажиллагаанд соргоор нолоолж болохын зэрэгцээ торсний дараа нярайн гадаад орчинд дасан зохицох чадварт муу нолоо үзүүлдэг.

Жирэмсэн вед эмийг хэрэглэх зайлшгүй шаардлага гарвал эмчээс зовлогоо авч, хориглох заалт бий эсэхийг тодорхой мэдсэний дараа хэрэглэх нь зүйтэй.

Жирэмсэн эх:

- Жирэмсний эхний 3 сард аль болох эм хэрэглэхгүй байх.
- Ургийн хогжилд эм муугаар нолоолөхгүй вед, эмчийн заалтаар эмийг хэрэглэх.
- Урагт хэрхэн нолоолох нь тодорхойгүй, шинэ эмийг жирэмсэн вед хэрэглэхгүй байх.
- Эмийг аль болох эмчилгээний бага тунгаар хэрэглэх зарчмыг баримталбал та болон таны үр хүүхдийн эрүүл мэндэд ашигтай.

Жирэмсэн вед сорог нолоо үзүүлдэг нь илэрхий болсон эмийг урагт нолоолох байдлаар нь: Хүчтэй, дунд, бага сорог нолоотэй гэж ангилдаг.

Жирэмсэн вед хвчтэй сорог нолоо вэvvлэх (ургийн хогжлийг зогсоох, зулбуулах, амьгвй ураг торvvлэх г.м) эм:

- Цитостатикууд: метотрексат, циклофосфамид, винкристин, фторурацил гэх мэт
- Моогонцорийн ба хавдрын эсрэг нолоот антибиотикүүд: актиномицин, рубомицин г.м
- Иммунодепрессантууд: азатиопирин г.м

Жирэмсэн вед дунд зэрэг сорог нолоо вэvvлэх (ургийн гаж болон дутуу хогжил г.м) эм:

- Зарим антибиотик: аминогликозидын ба тетрациклиний бвлэг (Хлорамфеникол, гентамицин, стрептомицин, тетрацилин, доксацилин г.м)
- Хими заслын зарим эм: аминохинолоны уламжлалын болон хининий бэлдмэл (ципрофлоксацин, офлаксацин, делагил г.м)
- Таталдаа намдаах зарим эм: дифенин (Phenyton), финлепсин карбамазепин г.м
- Паркинсонизмыг эмчлэх эм (леводопа)
- Литийн давс
- Стероид ба стеройд бус врэвслийн эсрэг нолоот эм (преднизолон, индометацин г.м)
- Ууж хэрэглэдэг чихрийн шижингийн эсрэг нолоот эм (метформин)
- Нейролептик эм: (галоперидол г.м)
- Этилийн спирт
- Шууд бус нолоот антикоагулянт (варфарин г.м)
- Бамбай булчирхайн хордлогыг эмчлэх эмvвд (мерказолил г.м)

Жирэмсэн вед бага зэрэг сорог нолоо вэvvлж болох (ургийн торолтийн хvндрэл vvcэх, эхийн артерийн даралт унах г.м) эм:

- Сульфаниламидууд, ялангуяа бисептол (септрин)
- Микробын эсрэг нолоот нийлэг эм (метронидазол г.м)
- Гурван цагирагт антидепрессант г.м (амитриптилин г.м)
- Транквилизатор (мепробамат г.м)
- Бэлгийн гормон (эстрогенууд г.м)